

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛ
2026 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН ТАЙЛАН

АГУУЛГА

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ЗАХ ЗЭЭЛИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД.....	1
1.1. ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ	1
1.2. ХӨРВӨХ ЧАДВАР	2
1.3. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДЕКСҮҮД.....	2
ХОЁРДУГААР БҮЛЭГ. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТ, НИЙЛҮҮЛЭЛТ	3
2.1. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН НИЙЛҮҮЛЭЛТ	3
2.1.1. Хувьцааны арилжаа	3
2.1.2. Компанийн өрийн хэрэгслийн арилжаа	4
2.1.3. Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн арилжаа	5
2.1.4. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны арилжаа	5
2.2. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТ	6
2.2.1. Хөрөнгө оруулагчдын бүтэц	6
2.3. БИРЖИЙН БУС ЗАХ ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА	6
ГУРАВДУГААР БҮЛЭГ. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ОРОЛЦОГЧИД.....	8
3.1. Үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн оролцогчид	10
3.2. Мөнгөн хөрөнгийн номинал дансны тайлан	10
3.3. Гадаад арилжааны тайлан	11
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ХӨДӨӨ АЖ АХУЙН БОЛОН УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БИРЖИЙН АРИЛЖАА.....	12
4.1. Хөдөө аж ахуйн биржийн арилжаа	12
4.2. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжаа	13
ТАВДУГААР БҮЛЭГ. САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНООС АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН ОНЦЛОХ АРГА ХЭМЖЭЭ.....	14
5.1. Эрх зүйн зохицуулалт.....	14
5.2.Хамтын ажиллагаа	14


НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ЗАХ ЗЭЭЛИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Олон улсын валютын сан, Дэлхийн банкнаас хөгжингүй болон хөгжиж буй орнуудын хөгжлийн түвшнийг үнэлж, тогтоох хүрээнд хөрөнгийн зах зээлийн хөгжлийн голлох үзүүлэлтүүд болох дараах индикаторуудыг оруулсан байдаг: зах зээлийн үнэлгээ, зах зээлийн үнэлгээний ДНБ-д эзлэх хувь, хөрвөх чадвар, хувьцааны индекс.

1.1. ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 2026 оны нэгдүгээр улирлын байдлаар 13.69 их наяд төгрөгт хүрсэн нь 2025 оны жилийн эцэстэй харьцуулахад 1.36 хувиар буурсан, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6.73 хувиар өссөн үзүүлэлт бөгөөд уг үзүүлэлт нь 2025 оны үйлдвэрлэлийн аргаар тооцсон ДНБ-ний 15.22 хувьтай тэнцэж байна.

График 1. ДНБ-д харьцуулсан хөрөнгийн зах зээлийн үнэлгээ



Тайлбар: 2026 оны ДНБ гараагүй тул 2025 оны ДНБ-тэй харьцуулж тооцоолов.

Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн үнэлгээг бүрдүүлж байгаа үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй нийт 164 компаниас дараах 20 компанийн зах зээлийн үнэлгээ 12.38 их наяд төгрөгийн үнэлгээтэй байгаа нь хөрөнгийн зах зээлийн нийт үнэлгээний 90.45 хувийг бүрдүүлж байна.

Хүснэгт 1. Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 30 компани


№	Компанийн нэр	Эзлэх хувь	№	Компанийн нэр	Эзлэх хувь
1	“ХААН банк” ХК	20.45%	11	“Премиум нэксус” ХК	2.16%
2	“Тавантолгой” ХК	11.16%	12	“Сүү” ХК	1.50%
3	“Эрдэнэ ресурс девелопмент корпорэйшн” ХК	8.72%	13	“Говь” ХК	1.27%
4	“Хас банк” ХК	8.25%	14	“Тандэм Инвест ББСБ” ХК	1.15%
5	“Голомтбанк” ХК	7.63%	15	“Улсын Их Дэлгүүр” ХК	0.87%
6	“АПУ” ХК	7.31%	16	“Монгол даатгал” ХК	0.84%
7	“Худалдаа хөгжлийн банк” ХК	6.28%	17	“Монголын хөрөнгийн бирж” ХК	0.81%
8	“Инвекор ББСБ” ХК	5.00%	18	“Лэндмн ББСБ” ХК	0.80%
9	“Төрийн банк” ХК	2.61%	19	“Тутал” ХК	0.69%
10	“МИК холдинг” ХК	2.34%	20	“Эм Жи Эл Акуа” ХК	0.62%

Тайлбар: Зах зээлийн үнэлгээнд 100 хувь төрийн өмчит компанийн үнэлгээ ордоггүй болно.

1.2. ХӨРВӨХ ЧАДВАР

Тайлант хугацаанд хөрөнгийн зах зээлийн хөрвөх чадвар 2025 оны жилийн эцэстэй харьцуулахад 1.57 пунктээр буурч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.13 пунктээр өсөж, 0.50 хувьд хүрсэн байна. Манай улсын хөрөнгийн зах зээлийн хөрвөх чадвар бага байгаа нь хувьцааны хэт төвлөрөлтэй холбоотой юм. Тухайлбал 2026 оны нэгдүгээр улирлын байдлаар ТОП-20 индексэд багтах ХК-уудын хувьцааны төвлөрлийг тооцож үзэхэд хэт төвлөрөлтэй буюу нийт хувьцааны 80.53 хувийг 5-аас дээш хувийн хувьцаа эзэмшигчид эзэмшиж байна.

График 2. Хөрвөх чадвар (хувиар)



1.3. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДЕКСҮҮД

“Монголын хөрөнгийн бирж” ХК-аас ТОП-20, MSE-A, MSE-B гэсэн гурван төрлийн хувьцааны үнийн индексүүдийг тооцон гаргадаг. ТОП-20 индексээр зах зээлийн үнэлгээ болон хувьцаа нь идэвхтэй арилжаалагддаг нэр бүхий 20 компанийн, MSE-A болон MSE-B индексээр үнэт цаасны бүртгэлийн I, II ангилалд багтсан компаниудын хувьцааны үнийн индексийг тус тус харуулдаг байна.

Хүснэгт 2. Индексийн үзүүлэлт

Индекс	2025.I	2025.IV	2026.I	Өөрчлөлт /2025.I-2026.I/	Өөрчлөлт /2025.IV-2026.I/
ТОП 20	50,171.38	54,478.17	52,126.33	3.90%	-4.32%
MSE A	19,422.59	20,822.95	20,154.75	3.77%	-3.21%
MSE B	14,729.13	14,361.75	14,438.18	-1.98%	0.53%

Эх сурвалж: “Монголын хөрөнгийн бирж” ХК

ТОП-20 индексийн дээд үзүүлэлт тайлант хугацааны байдлаар 53,411.40 нэгж, доод үзүүлэлт 51,670.91 нэгж, дундаж үзүүлэлт 52,428.06 нэгж байна. 2025 оны жилийн эцэстэй харьцуулахад 2,351.84 нэгжээр буюу 4.32 хувиар буурч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1,954.95 нэгжээр буюу 3.90 хувиар өсөж **52,126.33** нэгж болсон байна.

MSE-A индексийн дээд үзүүлэлт тайлант хугацааны байдлаар 20,439.20 нэгж, доод үзүүлэлт 20,013.57 нэгж, дундаж үзүүлэлт 20,167.45 нэгж байна. 2025 оны жилийн эцэстэй харьцуулахад 668.20 нэгжээр буюу 3.21 хувиар буурч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 732.16 нэгжээр буюу 3.77% хувиар өсөж, **20,154.75** нэгж болсон байна.

Харин MSE-B индексийн дээд үзүүлэлт 14,718.97 нэгж, доод үзүүлэлт 14,332.91 нэгж, дундаж үзүүлэлт 14,564.90 нэгж байна. 2025 оны жилийн эцэстэй харьцуулахад 76.43 нэгжээр буюу 0.53 хувиар өсөж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 290.95 нэгжээр буюу 1.98% хувиар буурч, **14,438.18** нэгж болсон байна.


ХОЁРДУГААР БҮЛЭГ. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТ, НИЙЛҮҮЛЭЛТ

2.1. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН НИЙЛҮҮЛЭЛТ

2026 оны нэгдүгээр улирлын байдлаар нийт **348.90** тэрбум төгрөгийн үнэт цаасны арилжаа хийгдсэн нь өмнөх оны мөн үеэс 69.01 хувиар өссөн үзүүлэлт бөгөөд өдрийн дундаж арилжаа **5.91** тэрбум төгрөг байна. Үүнээс арилжаа эрхлэх байгууллагаар дамжин хийгдсэн арилжааны дүн 269.54 тэрбум төгрөг буюу нийт арилжааны 77.25 хувь, хамтын нээлттэй хөрөнгө оруулалтын сангаар дамжин хийгдсэн арилжаа 79.36 тэрбум төгрөг буюу нийт арилжааны 22.75 хувийг тус тус эзэлж байна.

Тайлант хугацаанд хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны арилжаа түлхүү явагдсан бөгөөд нийт үнэт цаасны арилжааны 27.99 хувийг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, 22.91 хувийг хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх, 19.73 хувийг хувьцаа, 17.19 хувийг Засгийн газрын үнэт цаас, 12.19 хувийг компанийн бонд тус тус эзэлж байна.


График 3. Үнэт цаасны арилжааны хэмжээ (бүтээгдэхүүний төрөл, хувиар)



2.1.1. Хувьцааны арилжаа

График 4. Хувьцааны арилжаа (тэрбум төгрөгөөр)

Тайлант хугацаанд нийт 68.85 тэрбум төгрөгийн хувьцааны арилжаа хийгдсэн нь өмнөх оны мөн үеэс 43.70 хувиар өссөн үзүүлэлт юм.



Хоёрдогч зах зээл дээрх хувьцааны арилжааг арилжаа эрхлэх байгууллага дээр бүртгэлтэй, арилжааны хэмжээгээрээ тэргүүлэгч 30 компанийн арилжааны мэдээллийг үнийн дүнгээр харуулбал:

Хүснэгт 3. Арилжааны хэмжээ хамгийн өндөр 30 компанийн арилжааны үнийн дүн (тэрбум төгрөгөөр)

№	Компанийн нэр	Үнийн дүн	№	Компанийн нэр	Үнийн дүн
1	“Голомтбанк” ХК	25.19	16	“Худалдаа хөгжлийн банк” ХК	0.60
2	“ХААН банк” ХК	10.97	17	“Монложистик холдинг” ХК	0.59
3	“Премиум нэксус” ХК	6.74	18	“Шивээ-Овоо” ХК	0.55
4	“Инвескор ББСБ” ХК	6.03	19	“Түмэн шувуут” ХК	0.45
5	“АПУ” ХК	3.03	20	“Мандал даатгал” ХК	0.39
6	“Ард санхүүгийн нэгдэл” ХК	1.85	21	“Төрийн банк” ХК	0.33
7	“Эрдэнэ ресурс девелопмент корпорэйшн” ХК	1.62	22	“Моносхүнс” ХК	0.30
8	“Монголын хөрөнгийн бирж” ХК	1.35	23	“Талх чихэр” ХК	0.28
9	“Инновэйшн инвестмент” ХК	1.31	24	“Сүү” ХК	0.19
10	“Лэндмн ББСБ” ХК	1.18	25	“Ард Даатгал” ХК	0.18
11	“Тавантолгой” ХК	1.15	26	“Жуулчин дютти фрий” ХК	0.18
12	“Хөвсгөл алтан дуулга” ХК	0.92	27	“Говь” ХК	0.18
13	“Ард кредит ББСБ” ХК	0.82	28	“Улсын их дэлгүүр” ХК	0.13
14	“Хас банк” ХК	0.75	29	“Тэнгэрдаатгал” ХК	0.13
15	“Эм Жи Эл Акуа” ХК	0.71	30	“Газар шим үйлдвэр” ХК	0.10
НИЙТ					68.22

Эх сурвалж: “Монголын хөрөнгийн бирж” ХК

Тайлант хугацаанд нийт 8 хувьцаат компанийн 45.65 сая ширхэг буюу 29.56 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий багцын арилжаа хийгдсэн нь нийт хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжааны 42.93 хувийг эзэлж байна.

Хүснэгт 4. Багцын арилжаа хийгдсэн компаниуд


№	Үнэт цаасны нэр	Арилжаалагдсан ширхэг (мянган ширхэг)	Үнийн дүн (тэрбум төгрөг)
1	“Ард санхүүгийн нэгдэл” ХК	443.82	1.24
2	“Ар Баянхангай” ХК	4.20	0.003
3	“Ард кредит ББСБ” ХК	5,821.20	0.70
4	“Премиум нэксус” ХК	23,076.92	6.47
5	“Голомтбанк” ХК	11,285.45	14.66
6	“Инвескор ББСБ” ХК	582.17	5.52
7	“Эм Жи Эл Акуа” ХК	2,777.78	0.64
8	“Монложистик холдинг” ХК	1,658.82	0.31
НИЙТ		45,650.35	29.56

Эх сурвалж: “Монголын хөрөнгийн бирж” ХК

2.1.2. Компанийн өрийн хэрэгслийн арилжаа

График 5. Компанийн өрийн хэрэгслийн арилжаа (тэрбум төгрөгөөр)

Тайлант хугацаанд компанийн өрийн хэрэгслийн арилжаагаар нийт 42.51 тэрбум төгрөгийн арилжаа явагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 13.75 хувиар буурсан үзүүлэлт юм.




2.1.3. Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн арилжаа

Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль батлагдсанаас хойш 2026 оны нэгдүгээр улирлын байдлаар нийт 38 компани хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байна.

Тайлант хугацаанд Санхүүгийн зохицуулах хороо 4 компанийн хувийн хөрөнгө оруулалтын сан үүсгэн байгуулах баримт бичгийг бүртгэж, 1 хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон байна.


График 6. Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн арилжаа (тэрбум төгрөгөөр)



Тайлант хугацаанд хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн анхдагч зах зээлд нийт 1.00 тэрбум, хоёрдогч зах зээлд нийт 78.92 тэрбум төгрөгийн арилжаа хийгдэж өмнөх оны мөн үеэс 1.30 дахин өссөн үзүүлэлттэй байна.

График 7. Тайлант хугацаанд хийгдсэн хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн арилжааны задаргаа

Тайлант хугацаанд хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн хоёрдогч зах зээлийн нийт 79.92 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэнээс биржээр арилжаалагддаг хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангаар 0.56 тэрбум төгрөгийн арилжаа, хамтын нээлттэй хөрөнгө оруулалтын сангаар 79.36 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн нь тус тус нийт арилжааны 0.71 болон 99.29 хувийг бүрдүүлж байна.




- Хамтын хаалттай ХОС, ETF
- Хамтын нээлттэй ХОС

2.1.4. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны арилжаа

График 8. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны арилжаа (тэрбум төгрөгөөр)

Тайлант хугацаанд хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаагаар 82.00 тэрбум төгрөгийн арилжаа, хоёрдогч зах зээлд нийт 15.64 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн нь өмнөх оны мөн үеэс 30.92 хувиар өссөн үзүүлэлт юм.



- Анхдагч зах зээл
- Хоёрдогч зах зээл

2.2. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТ


Тайлант хугацаанд 1,689 шинэ данс, 11,693 холболтын данс шинээр нээгдэж өссөн дүнгээр нийт 2,612,233 данс, 732,051 холболтын данс “ҮЦТХТ” ХХК-д бүртгэлтэй байна.

2.2.1. Хөрөнгө оруулагчдын бүтэц

График 9. Гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын арилжааны үнийн дүнд эзлэх хувь

Тайлант хугацаанд нийт хоёрдогч зах зээлийн арилжаанд дотоодын иргэний хийсэн арилжаа 122.10 тэрбум төгрөг (70.84 хувь), дотоодын аж ахуйн нэгжийн хийсэн арилжаа 47.36 тэрбум төгрөг (27.48 хувь), гадаадын иргэний хийсэн арилжаа 1.07 тэрбум төгрөг (0.62 хувь), гадаадын аж ахуйн нэгжийн хийсэн арилжаа 1.82 тэрбум төгрөг (1.06 хувь)-ийг тус тус эзэлж нийт 172.32 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн байна.

Дээрх арилжаанд давтагдсан тоогоор нийт 167,669 иргэн, 629 аж ахуйн нэгж оролцож, 1,219,167 удаагийн арилжаа хийсэн байна. (Дэлгэрэнгүйг доорх хүснэгтээс харна уу.)



Эх сурвалж: "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК, "Улаанбаатар үнэт цаасны бирж" ХК, Хамтын нээлттэй хөрөнгө оруулалтын сангийн тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхлэх этгээдүүд

Хүснэгт 5. Хөрөнгө оруулагчдын бүтэц (давтагдсан тоо, хувиар)

	Арилжаанд оролцогчийн тоо		Арилжаанд оролцсон тоо	
	Тоо	Хувь	Тоо	Хувь
Гадаадын ААН	33	0.02%	271	0.02%
Гадаадын иргэн	287	0.17%	1,341	0.11%
Дотоодын ААН	596	0.35%	3,742	0.31%
Дотоодын иргэн	167,382	99.46%	1,213,813	99.56%
Нийт	168,298	100.00%	1,219,167	100.00%

Эх сурвалж: "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК, "Улаанбаатар үнэт цаасны бирж" ХК, Хамтын нээлттэй хөрөнгө оруулалтын сангийн тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхлэх этгээдүүд

2.3. БИРЖИЙН БУС ЗАХ ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА


Биржийн бус зах зээлийн үйл ажиллагаа эхэлсэн өдрөөс буюу 2021 оны 09 дүгээр сараас 2026 оны нэгдүгээр улирал хүртэлх хугацаанд биржийн бус зах зээлд нийт 225 үнэт цаас гаргагчийн 464 хөтөлбөр бүртгэгдэж, 1392 өрийн хэрэгсэл амжилттай санхүүжилт татан төвлөрүүлжээ.

Тухайлбал, төгрөгөөр 7.16 их наяд төгрөг, 330.92 сая ам.долларын үнийн дүн бүхий хөтөлбөр бүртгэгдэж, 5.46 их наяд төгрөгийн, 189.87 сая ам.долларын үнийн дүн бүхий санхүүжилтыг тус тус амжилттай татан төвлөрүүлжээ.

Үүнээс тайлант хугацаанд 33 үнэт цаас гаргагчийн 589.77 тэрбум төгрөг, 68.00 сая ам долларын үнийн дүн бүхий 34 хөтөлбөр бүртгэгдэж, 139 өрийн хэрэгсэл 458.16 тэрбум төгрөг, 8.50 сая ам.долларын үнийн дүн бүхий санхүүжилтыг тус тус амжилттай татан төвлөрүүлжээ.


Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад бүртгэгдсэн үнийн дүн 1.84 дахин, бодит татан төвлөрүүлсэн дүн 63.03 хувиар тус тус өссөн үзүүлэлт юм.

График 10. Тайлант хугацаанд ББЗЗ-д бүртгэгдсэн нийт өрийн хэрэгслийн дүн болон бодит татан төвлөрүүлсэн дүн




Тайлант хугацаанд бүртгэгдсэн нийт өрийн хэрэгслийг үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны салбараар нь ангилбал хөрөнгө оруулалт 36.43 хувь, уул уурхай олборлолт 22.76 хувь, барилга, зам тээвэр 14.09 хувь, банк бус санхүүгийн байгууллага 9.26 хувь, барьцаалан зээлдүүлэх газар 7.21 хувь, худалдаа, үйлчилгээ 2.76 хувь, үйлдвэрлэл 2.58 хувь, хөдөө аж ахуй 2.40 хувь, боловсрол, эрүүл мэнд 1.56 хувь, үнэт цаасны компани 0.60 хувь, эрчим хүч 0.21 хувь, бусад салбар 0.12 хувийг тус тус бүрдүүлж байна.

График 11. Тайлант хугацаанд ББЗЗ-д бүртгэгдсэн нийт өрийн хэрэгслийн дүнг үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны салбараар (хувиар)



2026 оны нэгдүгээр улирлын байдлаар биржийн бус зах зээлд нийт 1,221.19 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн бөгөөд анхдагч зах зээлийн арилжаа 488.49 тэрбум төгрөг, хоёрдогч зах зээлийн арилжаа 732.70 тэрбум төгрөг байна. Энэхүү үзүүлэлт нь өмнөх оны мөн үеэс 59.17 хувиар өссөн үзүүлэлт байна.

График 13. ББЗЗ-ийн арилжаа (их наяд төгрөгөөр)



ГУРАВДУГААР БҮЛЭГ. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ОРОЛЦОГЧИД

Өнөөдрийн байдлаар үнэт цаасны зах зээл дээр Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Компанийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Компанийн тухай хууль, Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль, Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль, Инновацийн тухай хууль зэрэг хуулиуд хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Эдгээр хууль болон бусад холбогдох дүрэм, журам, зааврын хэрэгжилтэд хяналт тавих, санхүүгийн үйлчилгээг зохицуулах, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах чиг үүргийг Санхүүгийн зохицуулах хороо хэрэгжүүлж байна.

Дээрх хууль тогтоомжийн хүрээнд тайлант хугацаанд Санхүүгийн зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл болон бүртгүүлсний үндсэн дээр үйл ажиллагаа эрхэлж буй 334 зохицуулалттай этгээд байна.

Хүснэгт 6. Үнэт цаасны зах зээлд оролцогчид

№	Үйл ажиллагааны төрөл	Тоо
Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхлэгч		
1	Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага	3
2	Үнэт цаасны клирингийн байгууллага	2 ¹
3	Үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэлийн байгууллага	4
4	Үнэт цаасны төлбөрийн байгууллага	1 ²
5	Хөрөнгө оруулалтын менежментийн компани	38
	Үнэт цаас итгэмжлэн удирдах үйлчилгээ үзүүлэх этгээд	3 ³
6	Хамтын хөрөнгө оруулалтын сан /хаалттай, нээлттэй/	9
7	Үнэт цаасны компани	52

¹ Тус тоонд үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага болох “Улаанбаатар Үнэт Цаасны Бирж” ХК болон “ҮЦТХТ” ХХК орсон болно.

² “ҮЦТХТ” ХХК нь үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэлийн болон төлбөрийн үйл ажиллагааг үзүүлдэг.

³ Нэр бүхий 3 хөрөнгө оруулалтын менежментийн компани болон 1 этгээд тус үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна /“Инвекстор ассет менежмент” ХХК, “Балансэд грэут менежмент” ХХК, “Үнэт ассет менежмент” ХХК /.

	Брокер	51
	Үүнээс:	
	Гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах үйл ажиллагаа эрхлэгч	20
	Номиналь дансаар дамжуулан харилцагчдад мөнгөн хөрөнгийн орлого, зарлагын гүйлгээний үйлчилгээний үйлчилгээ үзүүлэгч	22
	Үнэт цаасны номиналь дансаар дамжуулан харилцагчид үйлчилгээ үзүүлэгч	3
	Дилер	35
	Андеррайтер	26 ⁴
	Хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ үзүүлэгч	26 ⁵
8	Хөрөнгө итгэмжлэн удирдагч	5
9	Барьцаат үнэт цаасны хөрөнгийн багцын бүртгэлийг хянагч	2
10	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тусгай зөвшөөрөлтэй компани	74 ⁶
11	ХАА-н гаралтай бараа, түүхий эдийн биржийн үйл ажиллагаа эрхлэх байгууллага	1
12	ХАА-н биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагаа эрхлэх байгууллага	9
13	Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн үйл ажиллагаа эрхлэх байгууллага	1 ⁷
14	Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны зуучлагч /брокер/	15 ⁸
15	Санхүүжих чадавхын зэрэглэл тогтоох байгууллага	4
Бүртгэлтэй хөндлөнгийн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд		
16	ҮЦЗЗ-д оролцогчид аудитын үйлчилгээ, хөрөнгийн үнэлгээ үзүүлэгч байгууллага	78 ⁹
	Аудитын үйлчилгээ үзүүлэгч байгууллага	58
	Хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэгч байгууллага	25
17	ҮЦЗЗ-д оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэгч байгууллага	50
Нийт (Тусгай зөвшөөрөлтэй болон бүртгүүлсний үндсэн дээр үйл ажиллагаа эрхэлж буй компаниудын тоо)		334

Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй нийт 164 ХК байна. Мөн Хорооны 2015 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 273 дугаар тогтоолоор “Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо” ГҮТББ-ыг, 2015 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 379 дүгээр тогтоолоор “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийг өөрийгөө зохицуулах байгууллагаар тус тус бүртгэсэн.

Хүснэгт 7. Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй ХК-ийн тоо болон зах зээлийн үнэлгээ

Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагын нэр	Бүртгэлтэй ХК-ийн тоо	Зах зээлийн үнэлгээ 2024
1) “Монголын хөрөнгийн бирж” ХК -100 хувь төрийн өмчит -Төрийн өмчийн оролцоотой -Бусад	162 3 11 148	13,670,027,242,238.90 ₮ (Тус биржийн зах зээлийн үнэлгээнд 100 хувь төрийн өмчит компанийн үнэлгээ ордоггүй болно.)
2) “Улаанбаатар үнэт цаасны бирж” ХК	2	20,063,395,601.00 ₮
3) “Чингис хаан хөрөнгийн бирж” ХХК	-	-

⁴ Тус тоонд андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 2 банк /“Голомт банк” ХК, “Тээвэр Хөгжлийн банк” ХХК/ орсон болно.

⁵ Нэр бүхий 4 хөрөнгө оруулалтын менежментийн компани тус үйл ажиллагааг давхар эрхлэн гүйцэтгэх тусгай зөвшөөрлийг /“Балансэд грэүт менежмент” ХХК, “Үнэт ассет менежмент” ХХК, “Блак свон” ХХК, “Нийслэлийн өмчит Улаанбаатар хөрөнгө оруулалт, менежмент ҮЦК” ХХК/ авсан.

⁶ Тус тоонд “МИК ОССК” ХХК-40, “ҮЦСК” ХХК-5, “НОСК” ХК-5, нээлттэй хүрээнд ХБУЦ гаргасан 23 ТЗК, хаалттай хүрээнд гаргасан 1 ТЗК тус тус орсон.

⁷ Тус тоонд үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага болох “Монголын хөрөнгийн бирж” ХК орсон болно.

⁸ Нэр бүхий 10 үнэт цаасны компани тус үйл ажиллагааг давхар эрхлэн гүйцэтгэх тусгай зөвшөөрлийг авсан.

⁹ ҮЦЗЗ-д оролцогчид аудитын үйлчилгээ, хөрөнгийн үнэлгээ үзүүлэх үйлчилгээг зэрэг үзүүлдэг 5 компани байна.

3.1. Үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн оролцогчид

2026 оны нэгдүгээр улирлын байдлаар Хороонд бүртгэлтэй 52 үнэт цаасны компани байна. Үүнээс тайлант хугацаанд тайлан ирүүлсэн 50 үнэт цаасны компанийн нийт хөрөнгө 286.11 тэрбум, нийт орлого 10.20 тэрбум төгрөг байна. Тус компаниудыг нийт хөрөнгийн хэмжээ болон нийт орлогын хэмжээгээр нь ангилан үзвэл дараах бүтэцтэй байна.

Хүснэгт 8. Үнэт цаасны компаниудын хөрөнгийн болон орлогын шатлалын бүтэц

Нийт хөрөнгө	ҮЦК-ийн тоо	Нийт орлого	ҮЦК-ийн тоо
0 – 100,000,000	4	0– 100,000,000	38
100,000,001 - 1,000,000,000	19	100,000,001 - 1,000,000,000	7
1,000,000,001 ба түүнээс дээш	27	1,000,000,001 ба түүнээс дээш	5

2026 оны нэгдүгээр улирлын байдлаар Хороонд бүртгэлтэй 38 хөрөнгө оруулалтын менежментийн компани байна. Тус компаниудын хувьд 48 хувийн хөрөнгө оруулалтын сан, 9 хамтын хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгийг хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний үндсэн дээр удирдан ажиллаж байна. Үүнээс тайлант хугацаанд тайлан ирүүлсэн 37 хөрөнгө оруулалтын менежментийн компаниудын нийт хөрөнгө 118.42 тэрбум, нийт орлого 1.62 тэрбум төгрөг байна. Тус компаниудыг нийт хөрөнгийн хэмжээ болон нийт орлогын хэмжээгээр нь ангилан үзвэл дараах бүтэцтэй байна.

Хүснэгт 9. Хөрөнгө оруулалтын менежментийн компаниудын хөрөнгийн болон орлогын шатлалын бүтэц

Нийт хөрөнгө	ХОМК-ийн тоо	Нийт орлого	ХОМК-ийн тоо
0 – 100,000,000	12	0 – 100,000,000	33
100,000,001 -1,000,000,000	13	100,000,001 -1,000,000,000	3
1,000,000,001 ба түүнээс дээш	12	1,000,000,001 ба түүнээс дээш	1

2026 оны нэгдүгээр улирлын байдлаар Хороонд бүртгэлтэй 9 хамтын хөрөнгө оруулалтын сан байгаагаас 6 нь хамтын нээлттэй, 2 нь хамтын хаалттай, 1 хамтын хаалттай биржээр арилжаалагдах сан хэлбэртэйгээр үйл ажиллагаа эрхэлж байна.

Харин Хороонд бүртгэлтэйгээр үйл ажиллагаа эрхэлж буй 48 хувийн хөрөнгө оруулалтын сан байна.

3.2. Мөнгөн хөрөнгийн номинал дансны тайлан

2026 оны нэгдүгээр улирлын байдлаар Хороонд бүртгэлтэй номинал дансаар дамжуулан харилцагчдад мөнгөн хөрөнгийн орлого, зарлагын гүйлгээний үйлчилгээ үзүүлэгч 22 компани байгаа бөгөөд нийт 1,408,510 бүртгэлтэй харилцагч байгаагаас 23,967 харилцагч үйлчилгээ авч, 179.20 тэрбум төгрөгийн арилжаа хийсэн байна.

Нийт номиналь дансаар дамжин хийгдсэн арилжааны 93.39 хувь “Монголын хөрөнгийн бирж” ХК, 0.82 хувь “Улаанбаатар үнэт цаасны бирж” ХК, 5.79 хувь “Чингис хаан хөрөнгийн бирж” ХХК байна. Мөнгөн хөрөнгийн номиналь дансны тайлан дараах бүтэцтэй байна.

Хүснэгт 10. Номинал дансаар дамжуулан харилцагчдад мөнгөн хөрөнгийн орлого, зарлагын гүйлгээний үйлчилгээ үзүүлсэн тухай тайлан (сая төгрөгөөр)

Тайлбар		Дүн
Номиналь дансаар хийгдсэн арилжааны дүн	МХБ-ээр хийгдсэн	167,353.28
	УБҮЦБ-ээр хийгдсэн	1,470.15
	ЧХХБ-ээр хийгдсэн	10,374.02
	Нийт	179,197.45
Нийт номиналь дансны тайлан	Нийт дансны хуулгаарх үлдэгдэл	40,654.95
	Эхний үлдэгдэл	31,282.93
	Орлого	366,407.94
	Зарлага	357,033.26
	Эцсийн үлдэгдэл	40,654.96
	Үүнээс: ҮЦК-ийн мөнгөн хөрөнгө	1,912.43
	Харилцагчдын мөнгөн хөрөнгө	43,220.29
Төгрөгийн номиналь дансны тайлан	Нийт дансны хуулгаарх үлдэгдэл	28,146.91
	Эхний үлдэгдэл	23,438.03
	Орлого	205,794.69
	Зарлага	201,089.79
	Эцсийн үлдэгдэл	28,146.91
	Үүнээс: ҮЦК-ийн мөнгөн хөрөнгө	1,070.94
	Харилцагчдын мөнгөн хөрөнгө	27,735.14
Гадаад валютын номиналь дансны тайлан	Гадаад валют	USD
	Нийт дансны хуулгаарх үлдэгдэл	12,508.04
	Эхний үлдэгдэл	7,844.89
	Орлого	160,613.25
	Зарлага	155,943.47
	Эцсийн үлдэгдэл	12,508.04
	Үүнээс: ҮЦК-ийн мөнгөн хөрөнгө	841.48
	Харилцагчдын мөнгөн хөрөнгө	15,485.15

3.3. Гадаад арилжааны тайлан

2026 оны нэгдүгээр улирлын байдлаар гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах үйл ажиллагаа эрхлэх 20 компани байгаа бөгөөд үүнээс 9 этгээд тайлант хугацаанд арилжаанд зуучилсан тухай тайлангаа ирүүлсэн байна. Тухайлбал, нийт 6,942 харилцагчаас 1,243 харилцагч 2,370.97 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий арилжаанд оролцсон байна.

Хүснэгт 11. Гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах үйл ажиллагааны тайлан (тэрбум төгрөгөөр)


Худалдан авсан/худалдсан	Харилцагчийн төрөл	Нийт арилжаа	Нийт харилцагч	Нийт оролцогч
Худалдан авсан	Дотоодын иргэн	1,072.99	1,879	572
	Дотоодын хуулийн этгээд	348.90	653	97
	Гадаадын иргэн	205.18	633	21
	Гадаадын хуулийн этгээд	19.58	588	17
	Өөрийн нэрийн өмнөөс хийсэн арилжаа	12.19	589	37
Худалдсан	Дотоодын иргэн	392.02	1,829	468
	Дотоодын хуулийн этгээд	126.09	233	14
	Гадаадын иргэн	181.91	201	14
	Гадаадын хуулийн этгээд	-	168	0
	Өөрийн нэрийн өмнөөс хийсэн арилжаа	12.10	169	3
Нийт:		2,370.97	6,942	1,243

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ХӨДӨӨ АЖ АХУЙН БОЛОН УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БИРЖИЙН АРИЛЖАА

4.1. Хөдөө аж ахуйн биржийн арилжаа

График 12. ХААБ-ээр арилжаалагдсан түүхий эдийн арилжаа (тэрбум төгрөгөөр)

Тайлант хугацаанд Хөдөө аж ахуйн бирж нь 41 удаагийн цахим арилжаа зохион байгуулан 131 хэлцлээр нийт 77.20 тэрбум төгрөгийн үнэ бүхий бараа, түүхий эдийн арилжаа хийсэн байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 23.88 тэрбум төгрөгөөр буюу 44.77 хувиар өссөн үзүүлэлт юм.



ХААБ-ээр дараах төрлийн бүтээгдэхүүнүүд арилжаалагдсан байна. Үүнд:

Зураг 1. Хөдөө аж ахуйн биржийн арилжаа




Хүснэгт 11. Хөдөө аж ахуйн биржийн арилжааны дүн (бүтээгдэхүүний төрлөөр)

Ямааны ноолуур	38,983,440,000.00
Хонины ноос	1,892,700,000.00
Ямааны завод ноос	35,276,402,000.00
Тэмээний ноос	1,024,700,000.00
Бодын хөөвөр	27,000,000.00
Нийт	77,204,242,000

Нийт арилжааны дийлэнх хувийг буюу 50.49 хувийг ямааны ноолуур, 45.69 хувийг ямааны завод ноос, 2.45 хувийг хонины ноос, 1.33 хувийг тэмээний ноос, 0.03 хувийг бодын хөөвөр тус тус эзэлж байна.

График 14. Нийт арилжаалагдсан хөдөө аж ахуйн биржийн арилжааны бүтэц (үнийн дүнд эзлэх хувиар)




2026 оны нэгдүгээр улирлын байдлаар хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий нэр бүхий 9 хуулийн этгээд байна. Тайлант хугацаанд 77.24 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсний 1.48 хувийг “Алтан шагай инпекс” ХХК, 23.05 хувийг “Хаан Тэлмэн” ХХК, 71.68 хувийг “Ханбүргэд Хэнтий” ХХК, 3.79 хувийг “Цэц инвест” ХХК тус тус бүрдүүлж байна.

4.2. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжаа

2026 оны нэгдүгээр улиралд нийт 143 удаагийн арилжаагаар 6.25 сая тонн нүүрсийг 1,913.99 тэрбум төгрөгөөр, 67 удаагийн арилжаагаар 1.33 сая тонн төмрийн хүдэр, баяжмалыг 295.67 тэрбум төгрөгөөр, 2 удаагийн арилжаагаар 16.00 мянган тонн зэсийн баяжмалыг 160.18 тэрбум төгрөгөөр тус тус арилжаалж, нийт **212** удаагийн арилжаагаар **7.59** сая тонн уул уурхайн бүтээгдэхүүнийг **2,369.84** тэрбум төгрөгөөр арилжаалсан ба өдрийн дундаж арилжаа **40.86** тэрбум төгрөгт хүрсэн байна. Нийт арилжаалагдсан бүтээгдэхүүнийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад биет хэмжээгээр 1.75 дахин, мөнгөн дүнгээр 2.55 дахин тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Тухайлбал өмнөх оны мөн үед нийт 94 удаагийн арилжаагаар 5.50 сая тонн уул уурхайн бүтээгдэхүүнийг 0.67 их наяд төгрөгөөр арилжаалсан байна.

График 15. Нийт арилжаалагдсан нүүрсний хэмжээ (төрөл, ангилал, хувиар)




Тайлант хугацаанд нийт 10 төрлийн 6.25 сая тонн нүүрс арилжаалагдсанаас 1/3 коксжих нүүрс 59.53 хувийг, баяжуулсан коксжих чанаргүй нүүрс 3.07 хувийг, баяжуулсан коксжих нүүрс 5.94 хувийг, баяжуулсан дунд зэрэг үнстэй хагас хатуу коксжих нүүрс 7.38 хувийг, баяжуулсан сул коксжих нүүрс 2.05 хувийг, дэгдэмхий бодис дунд, коксжих нүүрс

11.48 хувийг, дэгдэмхий бодис их, хийн нүүрс 0.10 хувийг, эрчим хүчний нүүрс 5.12 хувийг, чийг багатай хүрэн нүүрс 1.23 хувийг тус тус эзэлж байна.

График 16. Нийт арилжаалагдсан төмрийн хэмжээ (төрөл, ангилал, хувиар)

Тайлант хугацаанд нийт 1.33 сая тонн төмрийн хүдэр, баяжмал арилжаалагдсанаас 23.88 хувийг Fe-52%-ийн агууламжтай төмрийн хүдэр, 71.64 хувь Fe-58%-ийн агууламжтай төмрийн баяжмал, 4.48 хувийг Fe-65%-ийн агууламжтай төмрийн баяжмал тус тус бүрдүүлж байна.



ТАВДУГААР БҮЛЭГ. САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНООС АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН ОНЦЛОХ АРГА ХЭМЖЭЭ

Санхүүгийн зохицуулах хорооноос 2026 оны нэгдүгээр улирлын байдлаар хөрөнгийн зах зээлийн шимтгэл хураамжийг бууруулах замаар зээлийн хүүг бууруулах, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлд голчлон анхаарч дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

5.1. Эрх зүйн зохицуулалт

Улсын Их Хурлаас 2025 онд “Зээлийн хүүг бууруулах хүрээнд авах зарим арга хэмжээний тухай” 79 дүгээр тогтоолыг баталсантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хороо дотоодын аж ахуйн нэгжүүд болон мэргэжлийн оролцогчдын хөрөнгийн зах зээлд оролцох зардлын ачааллыг бууруулж, үнэт цаас гаргах замаар санхүүжилт татах боломжийг нэмэгдүүлэх бодлогын шийдвэр гаргаж, зохицуулалтын үйлчилгээний хөлс, шимтгэл, хураамжийг хувьцаанаас бусад үнэт цаасны арилжааны хэлцэл тус бүрийн үнийн дүнгээс тооцон авдаг зохицуулалтын үйлчилгээний хөлсийг 100 хувиар, арилжааны хэлцэл тус бүрийн үнийн дүнгээс тооцон авдаг хөлсийг 50 хувиар, мөн үнэт цаасны арилжаа эрхлэх этгээдүүдийн шимтгэлийн орлогоос тооцон авдаг зохицуулалтын үйлчилгээний хөлсийг 50 хувиар тус тус буурууллаа.

5.2. Хамтын ажиллагаа

Санхүүгийн зохицуулах хорооноос Монгол Улсын хөрөнгийн зах зээлийг

хөгжүүлэх, олон улсын зах зээлд сурталчлах, гадаадын хөрөнгө оруулагчдын оролцоог нэмэгдүүлэх, дотоодын компаниудад олон улсын зах зээлээс санхүүжилт татах боломжийг сайжруулах зорилгоор “Монголын хөрөнгийн зах зээлийг холбох нь” цуврал арга хэмжээг 2026 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр БНХАУ-ын Бээжин хотод зохион байгуулж, Монголын хөрөнгийн зах зээл, уул уурхайн салбарыг БНХАУ-ын эх газрын мужуудад таниулан сурталчлах, хоёр улсын хөрөнгийн биржүүдийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, дотоодын компаниудыг БНХАУ-ын биржүүдэд давхар бүртгүүлэх, хадгаламжийн сертификат гаргахад дэмжлэг үзүүлэх, гадаадын томоохон хөрөнгө оруулагчдын сонирхол, оролцоог нэмэгдүүлэхэд бодитой хувь нэмэр оруулсан арга хэмжээ боллоо.

Мөн Монгол Улсын хөрөнгийн зах зээлийг дунд болон урт хугацаанд тогтвортой, үе шаттайгаар хөгжүүлэх, зах зээлийн үр ашиг, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор Санхүүгийн зохицуулах хороо Олон улсын санхүүгийн

корпорац (ОУСК)-тай хамтран ажиллах харилцан ойлголцлын санамж бичгийг 2026.03.30-ны өдөр байгууллаа. Тус санамж бичгээр хоёр тал хөрөнгийн зах зээлийн өнөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, олон улсын жишиг болон ижил

түвшний, хөгжингүй зах зээлүүдтэй харьцуулсан үнэлгээ гаргана. Мөн өмнө хэрэгжүүлсэн бодлого, шинэчлэлийн үр нөлөөг үнэлж, цаашдын хөгжлийн тэргүүлэх чиглэл, бодлогын хэрэгжилтийн замын зураглалыг тодорхойлох юм.

ҮНЭТ ЦААСНЫ ГАЗАР

---o-0-o---

